



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/51

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.2, 4.1, 4.2 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч:

Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

1 Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

2 Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

3 Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

4 Д.Дэлгэрмаа

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Н.Дагиймаа


Хүний нөөцийн мэргэжилтэн

2.Албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хянан баталгаажуулсан тайланг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор үнэлгээний багт хүргүүлэхийг нэгжийн дарга нарт даалгасугай.

3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэж Даргын зөвлөлд танилцуулахыг үнэлгээний багт даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132013590